

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН САНАЛУУДЫН
НЭГТГЭЛ**

		Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
1.	Батлан Хамгаалах Яамны санал	Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Даатгалын асуудал хариуцсан хорооны үйл ажиллагаанд хяналт тавих” гэж нэмж тусгах;	Үгүй. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д “Хороо нь хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнана.”, 9.2-т “Хорооны үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Улсын Их Хурал зохих бүтцээрээ дамжуулан хяналт тавина.” гэж заасан тул уг саналыг тусгах шаардлагагүй гэж үзэв.
2.		Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн нэрийг “Даатгалын үйл ажиллагааг зохицуулах байгууллага” гэж, 34 дүгээр зүйлийн 34.4-т “... аудитын байгууллага байсан ...” гэснийг “... аудитын байгууллагад байсан ...” гэж, 64 дүгээр зүйлийн 64.1-д “... тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.” гэснийг “..., тараахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх;	Үгүй. Даатгалын үйл ажиллагаа гэдгийг хуулийн төслийн 4.1.10-д тодорхойлсон бөгөөд хуулийн төслийн 13-р зүйлийн нэр дэх даатгалын зохицуулах байгууллага нь зөвхөн даатгалын үйл ажиллагааг зохицуулах бус илүү өргөн хүрээний зохицуулалт хийхээр тусгагдсан байгаа. Мөн хуулийн төслийн 64.1-д ирүүлсэн саналыг тусгаагүй болно. Учир нь даатгагч өөрөө тараахаас гадна өөрийн зуучлагч этгээдүүдэд тараахыг зөвшөөрч болохгүй билээ.
		Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Хороо дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн даатгалын хэлбэр, төрлөөс хамааран нэмэлт шаардлага тавьж болно.”, 17.2-т “Хороо	Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 17.2-т “Хороо даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, зөвшөөрлийн хэлбэр, төрлөөс хамааран зөвшөөрөлд

3.	даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, зөвшөөрлийн хэлбэр, төрлөөс хамааран зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.” гэсэн зохицуулалтууд нь даатгалын үйл ажиллагаа эрхлэгч болон даатгалын үйл ажиллагаа эрхлэх өргөдөл гаргагч нарт хүнд суртал, чирэгдлийг үүсгэхээр байгааг анхаарах.	тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.” гэснийг “Хороо энэ хуулийн 17.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан болохыг нотлох нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.” гэж өөрчлөв.
4.	Хуулийн төслийн 25 дугаар зүйлд “Ногдол ашиг хуваарилах нөхцөл” гэсэн нь хуулийн төслийн 25.1-д “Ногдол ашиг хуваарилсны дараа дараах нөхцөлийн аль нэг нь үүсэхээр бол хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахгүй.” гэсэнтэй утга, найруулгын хувьд уялдахгүй байгааг анхаарах.	Тийм. 25 дугаар зүйлийн нэрийг “Ногдол ашиг үл хуваарилах нөхцөл” гэж өөрчлөв.
5.	Хуулийн төслийн 79 дүгээр зүйлийн 79.5-д “Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 78.4-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.”, 80 дугаар зүйлийн 80.3-т “Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 80.2-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.” гэсэн зохицуулалтууд нь зөвшөөрөл эзэмшигч холбогдох тайлбараа Хороонд ажлын 14 хоногийн дотор бичгээр ирүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй, хүчингүй болгохгүй байж болохоор хуулийн төсөл тусгагдсан байгааг тус тус анхаарах.	Тийм. “... гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ”. гэснийг “... гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлэх бөгөөд энэ хугацаанд ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.” гэж өөрчлөн найруулав.
6.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийг зөрчиж байх тул Даатгалын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “аннуити”, 4.1.8 дахь заалтын “Даатгалын омбудсман”, 4.1.13а дахь заалтын “бенефишер”, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг “Сэндбоксын зохицуулалтын орчин”, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийн “Компанийн засаглалын	Хэсэгчлэн тусгав. “даатгалын омбудсман” нэр томъёог “даатгалын маргаан таслах зөвлөл” гэж тусгав. Хуулийн төсөл дэх гадаад нэр томъёонууд нь олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бөгөөд Монгол хэлэнд оноосон нэр нь байхгүй.

		кодекс”, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын “банкашурэнс” гэснийг тус тус монгол хэлний оноосон нэрээр бичих;	Мөн хуульд тусгагдаагүй нэр томьёог захиргааны хэм хэмжээний актуудад ашиглахгүй учир уг хуулийн төсөлд тусгав.
7.		Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг даган гарах Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.57-д Эрх бүхий албан тушаалтныг томилох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо олгохоор байна. Даатгалын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтад “эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан этгээдийг ойлгоно гэж заасан тул бүх төрлийн компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг томилох тусгай зөвшөөрөл олгохоор байх тул “Эрх бүхий албан тушаалтныг томилох” гэснийг хасах;	Үгүй. Хуулийн төслийн 58.2 дэх хэсэгт заасны дагуу зохицуулагдаж байгаа учраас хасах боломжгүй.
8.	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны санал	Санхүүгийн Зохицуулах Хороо нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хууль санаачлах эрх эдлэхгүй тул Даатгалын тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах” гэснийг “даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах” гэж өөрчлөх;	Тийм. Хуулийн төслийн уг заалтыг “даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, хууль санаачлах эрх бүхий этгээдэд хүргүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах” гэж өөрчлөв.
9.		Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно гэж заасан тул “зөвшөөрөл авах хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт” батлах тухай Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, Даатгалын зуучлалын тухай хуулийн 6 дугаар	Үгүй. Бүрдүүлэх баримт бичиг нь Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төсөлд оруулсан бөгөөд бүрдүүлэх баримт бичгийн маягт жагсаалт нь уг журмын төслөөр зохицуулагдана. Уг төсөлд зөвшөөрөл олгох, татгалзахтай холбоотой харилцааг зохицуулаагүй, зөвхөн

		зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус хасах;	зөвшөөрлийн хүсэлт гаргахтай холбоотой харилцааг л зохицуулсан.
10.		Зөвшөөрлийг хуульд тодорхой заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд хүчингүй болгох шаардлагатай тул Даатгалын тухай хуулийн төслийн 80 дугаар зүйлийн 80.1.7 дахь заалт, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтыг тус тус заасныг хасах;	Үгүй. Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль гэх мэт бусад хуулийн дагуу хүчингүй болгох үндэслэлүүд гарч болно.
11.		Хороо нь зөвхөн зөвшөөрөл авсан этгээдүүдийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэхээс гадна даатгагч, даатгуулагч, даатгалын зуучлал нарын хооронд үүссэн маргааныг урьдчилан шийдвэрлэх шаардлагатай тул Даатгалын тухай хуулийн төслийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт “Зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан” гэсний дараа “даатгуулагч, даатгагчийн хооронд гарсан”, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт “Зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан” гэсний дараа “болон даатгагч, даатгалын зуучлал, даатгуулагч нарын хооронд гарсан” гэж тус тус нэмэх;	Хэсэгчлэн тусгав. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91-р зүйлд заасны дагуу даатгуулагч нь даатгагчид гомдол гаргах талаар, уг гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд даатгалын омбудсманд гомдол гаргах эрхтэй талаар даатгагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй гэж заасан болно. Харин даатгуулагчаас даатгалын зуучлагчид гомдол гаргах, маргааныг нь хэн шийдвэрлэх талаар тодруулж тусгав.
12.		Хуулийн төсөлд “Даатгалын омбудсман” гэх эрх бүхий байгууллагын талаар тусгасан байна. Тухайн байгууллагыг хэн, ямар журмаар байгуулах талаар хуулийн төсөлд тусгаагүй байх тул холбогдох зохицуулалтыг нэмэх;	Тийм. Даатгалын омбудсман буюу даатгалын маргаан таслах зөвлөлийг хэн, ямар журмаар байгуулах талаар дэлгэрэнгүй тусгав.
13.		Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1-д “... дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж, 12.1.3-т “хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг” гэж заасан бол 13 дугаар зүйлийн 13.2-т “Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж, 13.2.8-д “хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.” гэж өөр өөр байдлаар тусгажээ. Иймд чиг үүрэг, бүрэн эрх гэсэн ойлголтыг нэг мөр хуулийн төсөлд тусгах;	Тийм. 12.1.3-т “хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг” гэснийг “хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх” гэж өөрчлөв.
		Хуулийн төслийн 17.4-т зөвшөөрөлд тусгах мэдээллийг Зөвшөөрлийн тухай хуулийн зарим заалттай давхардуулан дурдсан байх тул Зөвшөөрлийн тухай	Тийм. Саналыг тусгав.

14.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам	хуульд зааснаас бусад мэдээллийг хуульчлах тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т заасны дагуу эшлэл хэрэглэх нь оновчтой болохыг анхаарах; Тухайлбал, “Зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд зөвшөөрөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгана.” гэж найруулах;	
15.		Хуулийн төслийн 50.1-т “Даатгагч нь энэ хуулийн 4.1.10-д зааснаас гадна холбогдох этгээдээс бусад этгээдэд дараах даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно.” гэж заажээ. Холбогдох этгээдээс бусад этгээд гэдэгт ямар этгээдийг хамааруулах нь тодорхойгүй байх тул тус заалтыг тодорхой болгох;	Үгүй. Хуулийн төсөлд "холбогдох этгээд" гэж даатгагчийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг," гэж тодорхойлсон. Уг заалтад холбогдох этгээдийг тодорхойлж өгсөн учир түүнээс бусад бүх этгээдэд даатгагч нь баталгаа, батлан даалт гаргаж болохоор зохицуулав.
16.		Хуулийн төслийн 50.3-т “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны журмыг ...” гэж заасан байна. Хуулийн төслийн 8.1 дэх хэсэгт “Хураамжийн хэмжээ нь актуар тооцоололд үндэслэнэ.” гэж заасан нь үйл ажиллагааны талаар зохицуулсан зохицуулалт биш болохыг анхаарах;	Тийм. Саналыг тусгав.
17.		Даатгалын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “актуарч”, 4.1.2-т “аннуити”, мөн 4.1.8-д “даатгалын омбудсман” зэрэг нэр томъёоны тодорхойлолтоор гадаад нэр томъёо ашигласан байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэж заасантай нийцэхгүй байх тул монгол хэлний дүрэмд нийцүүлэх;	Хэсэгчлэн тусгав. “даатгалын омбудсман” нэр томъёог “даатгалын маргаан таслах зөвлөл” гэж тусгав. Бусад нэр томъёоны хувьд хуульд тусгагдаагүй нэр томъёог захиргааны хэм хэмжээний актуудад ашиглахгүй учир уг хуулийн төсөлд тусгав.
18.		Даатгалын тухай хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 79, 80 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй	Үгүй. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3-д “Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож

	Зам, Тээврийн хөгжлийн яам	болох хүртэл хүчин төгөлдөр байна.”, мөн Даатгалын зуучлалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Энэ хуулийн 9.1 болон 10.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3-д “Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.” гэж заасантай нийцэхгүй байх тул тусгай зөвшөөрлийн хугацааг тодорхой заах;	болно.” гэж заасны дагуу уг хуульд хугацаагүй олгохоор заасан учраас зөрчилдөөгүй байгаа болно.
19.		Даатгалын тухай хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4-д “холбогдох этгээдийн бусдаас авсан зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргахыг хориглоно.” гэж заасан хэдий ч тус хуулийн төслийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Даатгагч нь энэ хуулийн 4.1.10-д зааснаас гадна холбогдох этгээдээс бусад этгээдэд даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно.” гэж зөрчилтэй заалт заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-д “зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” гэж заасантай нийцээгүй;	Үгүй. Хуулийн төслийн 26.1.4 болон 50.1 дэх заалтын дагуу даатгагч холбогдох этгээдийн баталгаа, батлан даалт гаргахыг хориглож байгаа бөгөөд холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргахыг зөвшөөрч байгаа болно. Иймээс уг 2 заалт нь хоорондоо зөрчилдөөгүй болно.
20.		Даатгалын тухай хуулийн төслийн 57.2-т “Цахим хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх, түүнд зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Хороо журам баталж болно.” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” гэж заасантай зөрчилдөж байх тул хуульд нийцүүлэх;	Тийм. Саналыг тусгав.
21.		Хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх засаглалын асуудлыг тодорхой тусгаагүй байна. Жолоочийн даатгалын тухай хууль батлахдаа Албан журмын даатгалын холбоонд жолоочийн даатгалын харилцааг зохицуулах Удирдах зөвлөл байхаар хуульчилсан байдаг. Удирдах зөвлөлийн 7 гишүүн (СЗХ -2, Сангийн яам -1, Тээврийн цагдаагийн алба -1, МҮЭХолбооны дэд	Үгүй. Хуулийн төсөлд Заавал даатгалын холбооны удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд зайлшгүй багтах төлөөллүүдийг тусгасан болно.

		ерөнхийлөгч, Монголын даатгалын холбооны ерөнхийлөгч, Мандал даатгалын компанийн дэд ерөнхийлөгч)-тэй байгаагийн 5 нь төрийн албан хаагч, дарга нараас бүрдүүлсэн. Санхүүгийн Зохицуулах Хорооноос Удирдах зөвлөлийг шууд томилохоор байгаа нь засаглалын хувьд буруу байгааг анхаарч үзээгүй байна. Гэтэл зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон тээвэрчид, даатгуулагчдын төлөөлөл байхгүй байх тул даатгалын харилцааг зохицуулах засаглалыг онцгой анхаарах шаардлагатай байна.	
22.	Барилга, Хот Байгуулалтын Яам	Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.1-д “Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэж заасан боловч даатгагч /түүний томилсон этгээд/-аас хохирлын үнэлгээг хэт багаар тогтоож иргэдийг хохироох тохиолдол гардаг тул энэ төрлийн зөрчил нь хөндлөнгийн үнэлгээ, дахин үнэлгээ зэрэг бусад нөхцөл байдлаар тогтоогдсон тохиолдолд даатгагч болон хөрөнгийн үнэлгээчинд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн төслийн 55 дугаар зүйлд нэмж тусгах;	Үгүй. Хохирол болон хөрөнгийн үнэлгээтэй холбоотой маргаан нь даатгалын онцлогтой холбоотойгоор бус, харин Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль гэх мэт хуулиудын дагуу шийдэгдэж, шалгагдаж зохицуулагдаж байгаа.
23.	Соёлын яамны санал	Даатгалын тухай хуулийн төслийн 6.2-д заасныг тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасантай уялдуулах, эсхүл төслийн 6.2.1-д “эрүүл мэнд” гэсний дараа “хариуцлага, ашиг сонирхолд” гэж нэмэх;	Үгүй. Амьдралын даатгал буюу урт хугацааны даатгал нь /life insurance/ зөвхөн даатгуулагчийн амь нас, эрүүл мэндэд гэрээгээр тохиролцсон эрсдэл учирсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлдөг даатгалын төрөл юм.
24.		Даатгалын тухай хуулийн төслийн 34.1.4-т “ноцтойгоор зөрчсөн” гэснийг тодруулах;	Тийм. 34.1.4 дэх заалтын доор “Энэ зүйлийн “ноцтойгоор” гэснийг аудит хийлгэж буй этгээд болон хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхол, санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн

			буюу үзүүлж болохуйц, эсхүл их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болохуйц үйлдлийг ойлгоно.” гэсэн тайлбар нэмж оруулав.
25.		Даатгалын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2.11 дэх заалтыг тус хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-д заасантай уялдуулах;	Тийм. “Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах;” гэснийг “Даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах;” гэж өөрчлөн найруулав.
26.		Даатгалын тухай хуулийн төслийн 51 дүгээр зүйлд “Тодорхойгүй хэлцлээс зайлсхийх” гэснийг Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд заасантай уялдуулах, эсхүл хасах;	Үгүй. Иргэний хуулийн 189 дүгээрийн зүйлийн дагуу гэрээний 2 тал гэрээний агуулгаа сайн дураар чөлөөтэй тодорхойлох боломжтой гэж заасан. Уг хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн заалт нь даатгалын гэрээ ойлгомжтой, товч тодорхой, хоёрдмол салаа утгагүй байгуулагдсан байх ёстой гэсэн агуулгатай. Хэрэв дээрх шаардлагыг хангаагүй бол хүчин төгөлдөр бус болох бөгөөд ийм хэлцлээс зайлсхийх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Энэ нь даатгалын гэрээний 2 талын ашиг сонирхлыг хамгаалсан учир зөрчилдөөгүй гэж үзсэн.
27.		Хуулийн төсөлд шинээр хэрэглэсэн гадаад үг, хэллэгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасантай уялдуулах, Монгол хэлний тухай хуульд заасан эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран монгол хэл рүү орчуулж хэрэглэх.	Хэсэгчлэн тусгав. “даатгалын омбусдман” нэр томьёог “даатгалын маргаан таслах зөвлөл” гэж тусгав. Хуулийн төсөл дэх гадаад нэр томьёонууд нь олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бөгөөд Монгол хэлэнд оноосон нэр нь байхгүй. Мөн хуульд тусгагдаагүй нэр томьёог захиргааны хэм хэмжээний актуудад

			ашиглахгүй учир уг хуулийн төсөлд тусгав.
28.	Цахим хөгжил, Харилцаа холбооны яам	Хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 8,9,10,11 дүгээр зүйлүүд нь уг бүлгийн зохицуулалтаас өөр харилцааг зохицуулсан байх тул энэ талаарх зохицуулалтыг тодорхой болгох;	Тийм. Саналыг тусгав.
29.		Хуулийн төсөлд заасан Хорооны тусгайлсан чиг үүргийг хуулийн төслийн 13.2-т заасан Хорооны бүрэн эрхэд шилжүүлж тусгах. Тухайлбал, хуулийн төслийн 28.2-т “Хороо энэ хуулийн 28.1-д заасан хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг тогтооно.”, 32.2.2-т “даатгалын байгууллагад аудит хийх эрхийг Хорооноос авсан байх”, 35-р зүйлд “Хороо аудит хийх хуулийн этгээдийг томилох”, 65.4-т “ Удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг Хороо батална.”, 65.6-д “Заавал даатгалын холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, зааврыг батлах ...” гэх зэрэг болно.	Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 13.2-т заасан Хорооны бүх эрхүүдийг дурдсан байгаа. Журам батлах эрхийг нь 13.2.6-д, зөвшөөрөл олгох эрхийг нь 13.2.3-д тусгасан болно.
30.		Хуулийн төслийн 50.3-т заасан үйл ажиллагааны журмыг хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан Хорооноос батлах даатгалын журамд тусгах;	Тийм. Саналыг тусгав.
31.		Хуулийн төслийн 79.3, 79.5-д заасан хугацааг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэгт заасан хугацаатай, мөн хуулийн төслийн 81.4-т заасан хугацааг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хугацаатай тус тус нийцүүлэх.	Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 81.4-т заасан хугацааг уг даатгалын тухай хуульд заасан зохицуулалтаар нарийвчлан тусгаж байгаа бөгөөд бусад саналыг нь тусгав.
32.		Төслийн 4.1.20-ыг хасаж, 7.2-ын “Хороо” гэснийг “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ гэж өөрчлөх;	Тийм. Хуулийн төслийн 6.4-т тусгав.
33.		Төслийн 10.2.7-ийн “үйл ажиллагаанд хяналт тавих” гэсэн нь оновчтой эсэх, хэрхэн хяналт тавих нь ойлгомжгүй тул тодорхой болгох;	Тийм. “... үйл ажиллагаанд ...” гэснийг “... гэрээний хэрэгжилтэд” гэж өөрчлөв.

34.	Эдийн засгийн хөгжлийн яам	Төслийн 14.2.11-ийн “хуулиас гадуур” гэснийг тодорхой болгох;	Тийм. “Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах;” гэснийг “Даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах;” гэж өөрчлөн найруулав.
35.		Төслийн 20.4-т дэх заалтын “хуулийн этгээд байх тохиолдолд” гэсний дараа “тухайн хуулийн этгээдийн” гэж нэмэх;	Тийм. Саналыг тусгав.
36.		Төслийн 57.1-ийн “сэндбокс” гэснийг нэр томъёоны тайлбарт оруулах;	Тийм. Нэр томъёоны тайлбарт оруулав.
37.		Төслийн 62.3.1-т заасан “эрх зүйн хэлбэр” гэснийг тодорхой болгох.	Тийм. Саналыг тусгав.
38.		Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт “Хороо даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам баталж болно” гэж заасан нь хоёрдмол утгыг илэрхийлж байгаа буюу Хороо тус журмыг заавал батлахаар тусгаагүй байна. Хэрэв Хороо тус журмыг батлахгүй тохиолдолд хуулийн төсөлд даатгалын нөхөн төлбөр олгох нарийвчилсан зохицуулалтыг тусгах шаардлагатайг анхаарах.	Үгүй. Нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг уг хуулийн төслийн 9-р зүйлд заасны дагуу зохицуулахаар нарийвчлан тусгасан байгаа учир “... нөхөн төлбөр олгохтой холбогдсон...” гэснийг “... нөхөн төлбөртэй холбогдсон...” гэж өөрчлөв.
39.		Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Даатгалын тохиолдлын улмаас хөрөнгө бүрэн утсан, сүйрсэн, дахин сэргээгдэх боломжгүй болсон тохиолдолд учирсан хохирлыг даатгагч бүрэн барагдуулсан тохиолдолд учирсан хохирлыг даатгуулагч болон хохирогч нь уг хөрөнгийг даатгагчид шилжүүлнэ” гэж заасны дагуу тухайн хөрөнгийг даатгагч авах үндэслэл, судалгаа тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, тухайн утсан, сүйрсэн, дахин сэргээгдэх боломжгүй болсон хөрөнгийг дахин үнэлэх зохицуулалт шаардлагатай эсэхийг нягтлах.	Үгүй. Даатгалын зарчмаар бол даатгуулагч нь даатгалаас ямар нэгэн ашиг олох ёсгүй, даатгуулагдсан эрсдэлээс учирсан хохирлыг нөхөн төлүүлж зөвхөн урьдын санхүүгийн байдлаа эргүүлэн олж авах явдал байдаг бөгөөд Иргэний хуулийн 510.1-д “Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр,

	Хууль зүй, Дотоод хэргийн яамны санал		төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.” гэж заасан. Нэгэнт даатгуулагчийг санхүүгийн урьдын байдалд оруулж даатгагч гэрээний дагуу үүргээ бүрэн биелүүлсэн бол уг хөрөнгийн үлдэх өртөг /англиар salvage/-ийг даатгагч авах эрхтэй талаар эрх зүйд тусгадаг байна.
40.		Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “нэхэмжлэн авах эрхийг шилжүүлэн авах” нэртэй байхаар заасан найруулгын хувьд алдаатай байх тул Иргэний хуулийн 443 дугаар зүйлийн 443.7 дахь хэсэгт “Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ” гэж заасантай нийцүүлэх, эсхүл эшлэх.	Тийм. “... нэхэмжлэн авах эрхийг шилжүүлэн авах ...” гэснийг “... нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах ...” гэж дахин найруулав.
41.		Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2.7 дахь заалтад заасан гэрээний хугацаанд даатгуулагчийн хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож үйл ажиллагаанд нь хэрхэн, ямар үндэслэлээр хяналт тавих нь тодорхойгүй байх тул нягтлах.	Тийм. “... үйл ажиллагаанд ...” гэснийг хасаж дахин найруулав.
42.		Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Хороо даатгалын зах зээлийг өргөжүүлэх, боловсронгуй болгох, даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан даатгалын журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж болно” гэж ерөнхий байдлаар тусгасныг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актын зохицуулах харилцааг нэг бүрчлэн тодорхой тусгах.	Үгүй. Хуулийн төслийн 14.3 заалт нь зөвхөн хэм хэмжээний актыг батлах биш, дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлахад хэрэглэнэ. Иймд хуулийн төсөлд тусгасан хэвээр байлгах нь зүйтэй гэж үзэв.
		Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт актуарчийн үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах шаардлагыг журмаар зохицуулах, мөн 57 дугаар зүйлийн	Тийм. Зөвшөөрлийн хуульд нийцүүлэн саналыг тусгав.

43.	57.2 дахь хэсэгт Хороо цахим хэлбэрээр үйл ажиллагааг эрхлэх, түүнд зөвшөөрөл олгох журам батлахаар тус тус заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт дагуу зөвшөөрөл олгох асуудлыг захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар гаргахыг хориглохоор заасантай нийцэхгүй байх тул зөвшөөрөл олгохтой холбогдох харилцааг хуулиар зохицуулах.	
44.	Хуулийн төслийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлэхээр заасан байна. Тус хэсэгт тодорхой программын нэр заасан нь цаашид бий болох өөр төрлийн хэрэгслийг хэрэглэх боломжийг хязгаарлах магадлалтай тул загварын нэрийг хасах. Түүнчлэн Сэндбоксын зохицуулалтын орчныг хэрхэн ойлгох талаар нэг томьёоны тодорхойлолт байхгүй болохыг анхаарах.	Хэсэгчлэн тусгав. Сэндбокс нь тухайлсан программын нэр бус, харин технологид суурилсан аливаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, загварыг нэрлэсэн олон улсад шинэ тутам нэвтэрч буй ойлголт бөгөөд “Сэндбоксын зохицуулалтын орчин” гэснийг нэр томьёоны тайлбарт хэсэгт тусгав.
45.	Хуулийн төслийн Арван гуравдугаар бүлэгт заасан даатгалын мэргэжлийн байгууллага буюу гишүүдийн эрх ашгийг хамгаалах, чадавхыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, даатгалын зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа эрхлэх ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулахаар зохицуулсан байх тул “ашгийн төлөө бус” хуулийн этгээд байхаар тусгах. Түүнчлэн тус ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэрийг “мэргэжлийн байгууллага” гэж тусгах нь оновчтой эсэхийг нягтлах. Мөн энэ төрлийн үйл ажиллагааг хэд хэдэн байгууллага эрхэлж болох эсэх нь тодорхойгүй байгааг анхаарах.	Үгүй. Ашгийн төлөө бус этгээд нь холбоо, сан, хоршоо зэрэг хэлбэрээр байдаг тул тус хуулийн төсөлд тусгасан мэргэжлийн байгууллага нь зөвхөн дээрх хэлбэрийн ашгийн төлөө бус этгээд байх бус бүхий л хэлбэрийн этгээд байх боломжтой юм. Энэ төрлийн үйл ажиллагааг хэд хэдэн байгууллага эрхэлж болох эсэхийг уг хуулийн төслийн 70.1.3-т заасны дагуу хэд хэдэн байгууллага эрхэлж болохоор зохицуулагдсан болно.
46.	Хуулийн төслийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт гомдол шийдвэрлэх эрх бүхий даатгалын омбудсманы талаар тусгасан боловч энэхүү эрх бүхий субъект нь урьдчилан шийдвэрлэх механизм эсэх, мөн түүний эрхлэх үйл ажиллагаа, эрх, үүрэг, гомдол шийдвэрлэх процедур	Тийм. Омбудсманы талаар тодорхой тусгаж оруулав.

		зэргийг тодорхой тусгаагүй байх тул нарийвчилсан зохицуулалтыг тусгах.	
47.		Хэрэглэгч буюу даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгалын үйл ажиллагаа хуулийн этгээдийн удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг бусад санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмших эрхэд хязгаарлалт тогтоосон олон улсын байгууллагын туршлагыг судалж, шаардлагатай тохиолдолд энэ талаарх зохицуулалтыг тусгах.	Тийм. Олон улсын туршлагыг судалж холбогдох зохицуулалтыг тусгахаар ажиллаж байгаа.
48.	Эрүүл мэндийн яамны санал	Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хариуцлагын даатгалд, ажилтнуудаа эрүүл мэндийн эрсдэлийн даатгалд хамруулах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллахаар болсон тул “Даатгалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор “Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” дагалдах хуулийн төслийг хасах саналтай байна.	Үгүй. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах бусад хуулиудад заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо болон тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлахаар заалтуудыг оруулж байгаа болно. Хэрэв уг ажлын хэсгээс холбогдох хуулийн төсөл боловсруулагдаж, УИХ-аар түрүүлж батлагдан гарвал уг дагалдах хуулийн төслийг хасахаар зохицуулав.